



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/33

Хэрлэн сүм

“Хүүхдийн хөгжил, хамгааллын жил”-ийн
нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүүхдийн хөгжил, хамгааллын жил”-ийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, нийгмийн хамгаалал хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Соёл, урлагийн газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн

2.Нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010363